



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/1297

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид барилга
байгууламжийг бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 112 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Энэ захирамжийн нэг, хоёрдугаар хавсралтад дурдсан Баянгол, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 7,389,704,416.00 (долоон тэрбум гурван зуун наян есөн сая долоон зуун дөрвөн мянга дөрвөн зуун арван зургаа) төгрөг, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж, ашиглалтад орсон 2,026,119,347.00 (хоёр тэрбум хорин зургаан сая нэг зуун арван есөн мянга гурван зуун дөчин долоо) төгрөг, нийт 9,415,823,763.00 (есөн тэрбум дөрвөн зуун арван таван сая найман зуун хорин гурван мянга долоон зуун жаран гурав) төгрөгийн өртөг бүхий 5 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2.Нийслэлийн өмчид шинээр бүртгэгдэж байгаа 5 барилга байгууламжийг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг эзэмшигч байгууллагын удирдлага нарт үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205576

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
11 сарын 04 өдрийн
№17291 захирамжийн
1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Барилга байгууламж ашиглалтад орсон огноо	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан огноо	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Эзэмшигч байгууллага
1	Баянгол дүүргийн 25, 28 дугаар хорооны цогцолбор барилга	Баянгол дүүргийн 25 дугаар хороо, Үйлдвэрийн бүс /16010/ Энхтайваны өргөн чөлөө гудамж, 43/4 тоот	2014.03.25	2024.04.26	4,189,704,416.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
2	267 дугаар цэцэрлэгийн Б барилга	Баянзүрх дүүргийн 14-р хороо, Консулын 20-р гудамж, 545-А тоот, Өгөөмөр захын хойд талд	2006.12.01	2023.06.15	1,600,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Баянзүрх дүүргийн 267 дугаар цэцэрлэг
3	319 дүгээр цэцэрлэгийн Б барилга	Баянзүрх дүүргийн 40-р хороо, Да хүрээ гудамжны 65/1 тоот, Грийн апартамент хотхоны урд талд	2016.04.20	2023.12.01	1,600,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Баянзүрх дүүргийн 319 дүгээр цэцэрлэг
Дүн					7,389,704,416.00		



Нийслэлийн Засаг даргын 2024 оны
11 дугаар сарын 04 өдрийн
А/129 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Барилга байгууламж ашиглалтад орсон огноо	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Эзэмшигч байгууллага
1	188 дугаар цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүргийн 33-р хороо, Тахилтын задгай, 122 дугаар сургуулийн хажуу талд	2023.12.18	1,040,726,183.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Сонгинохайрхан дүүргийн 188 дугаар цэцэрлэг
2	271 дүгээр цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүргийн 33-р хороо, Давхрын буудал, 10-р гудамж	2023.12.18	985,393,164.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Сонгинохайрхан дүүргийн 271 дүгээр цэцэрлэг
Дүн				2,026,119,347.00		